



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 4/74

Улаанбаатар хот

Сургалтын болон оюутны
байрны төлбөрийн талаар
авах зарим арга хэмжээний тухай


Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн “Шинэ коронавирусын эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 30 тоот тогтоол, 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” тогтоол, Улсын онцгой комиссын 2020 оны 01 дүгээр сарын 24, 03 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, шийдвэр, Улсын онцгой комиссын 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 02 дугаар тогтоол, БСШУС-ын сайдын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Шуурхай зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах тухай” А/43 тоот тушаал, Нийслэлийн засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/108 тоот захирамж, 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа ажлыг эрчимжүүлэх тухай” А/223 дугаар захирамж, МУИС-ийн Дүрмийн 4.3.1 дэх хэсэг, захиргааны зөвлөлийн 2020 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн өргөтгөсөн хурлын тэмдэглэл, шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шинэ төрлийн коронавирусын дэгдэлт дэлхийн улс орнуудад хурдтай тархаж, улс даяар хөл хорио тогтоож, хилийн зарим боомтыг түр хаасантай холбоотойгоор гадаад оюутнуудын 2019-2020 оны хичээлийн жилийн 2 дугаар улиралд төлсөн сургалтын төлбөрийг дараагийн хичээлийн жилийн сургалтын төлбөрт шилжүүлэн тооцсугай.

2. Оюутны байранд амьдарч буй гадаад, дотоод суралцагчдын 2019-2020 оны хичээлийн жилийн оюутны байрны төлбөрөөс хорио цээрийн хугацааны төлбөрийг дараагийн хичээлийн жилд шилжүүлэн тооцох, 2019-2020 оны хичээлийн жилд төгсөх суралцагчдын оюутны байрны төлбөрийн тооцоог суралцагчийг төгсөх үед нь бүрэн хийж дуусгахыг Санхүү, төлөвлөлтийн газрын дарга /Б.Энхцэцэг/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төлөвлөлт хариуцсан дэд захирал /Н.Бурмаа/, Захиргаа, хүний нөөцийн газрын дарга /Г.Мөнхбаяр/ нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Я.ТӨМӨРБААТАР

1117144746
УХД0072 9104399

3340300702